



МОНГОЛБАНК



БАНК-95 ЖИЛ

АЛТ ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАРЫН АВЛАГА

Эрдэнэсийн сан
2019

АГУУЛГА

Алтны үйл ажиллагааны талаар	3
1. Алт үнэ цэнээ хадгалдаг металл	3
2. Монголбанкны худалдан авсан алтны мэдээлэл	4
Алтны үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоол, журам	12
1. Монгол Улсын хууль	12
1.1. Төв банкны тухай хууль	12
1.2. Эрдэнэсийн сангийн тухай хууль	15
1.3. Ашигт малтмалын тухай хууль	17
1.4. Валютын зохицуулалтын тухай хууль	22
2. Засгийн газрын тогтоол	24
2.1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах аргачлал	26
3. Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал	
3.1. Журам батлах тухай (Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны журам)	29

АЛТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР


1. Алт үнэ цэнээ хадгалдаг металл

Алт нь үнэт металлын бүлэгт багтдаг дан элемент бөгөөд физик шинжийн хувьд давтагдах, сунамтгай чанараараа цахилгаан дулааныг маш сайн дамжуулдаг ба техникийн салбарт өргөн хэрэглэгддэг. Мөн маш нимгэн хуудас болгон давтаж, эсвэл маш нарийн утас болгон сунгаж болдог цорын ганц металл юм.

Харин эдийн засгийн хувьд алт нь хөрөнгийн үнэ цэнийг хадгалах хэрэгсэл гэдэг утгаараа эрт дээр үеэс төлбөр тооцоонд ашиглагдсаар ирсэн ба өнөөг хүртэл Төв банкнууд алтыг нөөцдөө хадгалсаар байна. Алт нь байгальд бусад элементүүдийн хамтаар оршдог (**бохир алт**) бөгөөд түүнийг бусад металлаас салган авч стандарт хэлбэрт шилжүүлэн боловсруулдаг (**цэвэршүүлсэн алт** буюу мөнгөжөөгүй алт). Энэхүү мөнгөжөөгүй алтыг олон улсын жишигт хүргэн цэвэршүүлэн, гадаад валютаар борлуулахад бэлэн болгон (**мөнгөжсөн алт**) олон улын санхүүгийн байгууллагуудад хадгалуулдаг.

Мөнгөжсөн алт нь тухайн орны мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах, эдийн засагт үүсэх эрсдэлийг бууруулах баталгаа болдог. Тиймээс Монголбанк нь Монгол Улсын валютын гадаад нөөцийг нэмэгдүүлэх, зохицуулах зорилгоор байгууллага, иргэдээс алтыг худалдан авч, гадаадад цэвэршүүлэх үйл ажиллагааг эрхэлдэг. Энэхүү үйл ажиллагааг Монголбанкны Эрдэнэсийн сан нь холбогдох хуульд заасны дагуу дараах байдлаар хэрэгжүүлдэг.

Дүрслэл 1. Монголбанкны Эрдэнэсийн сангийн алтны үйл ажиллагаа.




Гадаад валютын албан нөөц нэмэгдсэнээр 1) төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, 2) улс орны богино хугацаат гадаад зээлийн төлбөрийг төлөх чадварыг хангах, 3) Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн гадаад валютын баталгааг хангах, төгрөгийн ханшийг тогтвортой байлгах, 4) улс орныг бүхэлд нь хамарсан дотоод болон гадаад хүчин зүйлийн улмаас үүссэн эдийн засгийн хямралт байдлаас түргэн хугацаанд зардал багатайгаар гарах зэрэг ач холбогдолтой.

2. Монголбанкны худалдан авсан алтны мэдээлэл


2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголбанк дотоодын зах зээлээс нийт 22 тонн алт худалдан авсан байна. Худалдан авсан алтны хэмжээ 2018 онд 22 тонн байгаа нь 2010 оны худалдан авалттай харьцуулахад 10 дахин, 2014 оны худалдан авалтаас 72 хувиар тус тус өсжээ. Энэ нь 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрөөс “Ашигт малтмалын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулан $AMHAT=2.5\%+0\%$ болсон нь сүүлийн жилүүдэд алтны худалдан авалт нэмэгдэхэд нөлөөлсөн ба Монгол Улсын хууль эрх зүйн орчин сайжирсныг харуулж байна.

Зураг 1. Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ, дундаж үнэ



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2. Байгууллага, иргэдээс худалдан авсан алтны хэмжээ (кг)



Эх сурвалж: Монголбанк

“Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хууль” үйлчилж эхэлснээр алт олборлогч байгууллага, иргэдийн тоо эрс цөөрч алт худалдан авалт буурсан. Харин ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор байгууллага, иргэдийн алтыг Монголбанкинд төвлөрүүлэх болсон.

Монгол Улсаас алт худалдан авалтыг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг шат дараатайгаар хэрэгжүүлж байна. Үүнд:

1. 2006 оны 5 дугаар сарын 12-нд “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хууль” үйлчилж, 68%-ийн татвар авч эхэлсэн. Үүнээс болж 2006-2010 хүртэл алт худалдан авалтын хэмжээ буурсан. Тиймээс 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс энэхүү хуулийг хүчингүй болгон, “Ашигт малтмалын тухай хууль”-д өөрчлөлт оруулан $AMHAT=5\%+(0-ээс\ 5\ хүртэл)\%$ (зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарна) болсон. Ингэснээр 2011-2013 он хүртэл алт худалдан авалтын хэмжээ өссөн.
2. 2014 оны 1 дүгээр сарын 24-ны өдрөөс “Ашигт малтмалын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулан $AMHAT=2.5\%+0\%$ болсон ба энэхүү өөрчлөлт нь 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл дагаж мөрдсөн.
3. Улсын Их Хурлын 2019 оны 3 дугаар сарын 26-ны ээлжит бус чуулганаар “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг баталж $AMHAT=5\%+0\%$ болсон ба энэхүү өөрчлөлт нь 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрөөс дагаж мөрдөнө.

Монголбанк алт худалдан авалтыг нэмэгдүүлэх, албан бус сүлжээг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:

1. 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс Монголбанкинд худалдан авах алтны үнийг Лондонгийн үнэт металлын зах дээрх хамгийн сүүлийн алтны үнээс 2 ам.долларыг, цагаан

мөнгөний үнийг Лондонгийн үнэт металлын зах дээрх хамгийн сүүлийн цагаан мөнгөний үнээс 1 ам.долларыг хасч тооцдог болсон.

2. 2016 онд 11 дүгээр сарын 11-ний өдрөөс Монголбанк алт худалдан авах цагт өөрчлөлт оруулан Монголбанкны алт худалдан авах цагт амжиж алтаа худалдаагүй бол тухайн өдрийн алтны үнээр хадгалуулж, дараагийн өдөр төлбөр тооцоог шилжүүлдэг болсон.
3. “Алт 2” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2017 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс 3 сарын хугацаанд “Монгол алт” аян, 2018 оны 6 дугаар сарын 4-ний өдрөөс 5 сарын хугацаанд “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяныг зарласан бөгөөд 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 6 сарын хугацаанд “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяныг дахин зохион байгуулж байна. Аяны зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагууд олборлосон алтаа Монголбанк болон арилжааны банкуудад худалдаж, алт худалдан авалтыг нэмэгдүүлэх, олон нийтийн дунд алт худалдан авах үйл ажиллагааны талаар сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, холбогдох хууль, журмыг таниулахад оршино. Мөн Монгол Улсын гаалиар зөвшөөрөлгүй алт гаргах үйлдлийг бууруулах, хариуцлагатай уул уурхайг дэмжих, тэдний үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, Монголбанкны худалдан авч буй алтны үнийн талаар болон бусад мэдээллийг олон нийт, байгууллагад хүргэх, таниулах юм.
4. 2017 оны 8 дугаар сарын 7-ны өдрөөс алт тушаагч байгууллага, иргэдийн үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх зорилгоор “Тэрчлэх бичиг” олгож эхэлсэн.
5. 2018 оны 10 дугаар сард Дархан-Уул, Баянхонгор аймагт сорьцын лаборатори байгуулан, алт худалдан авалтын нэг цэгийн үйл ажиллагааг эхлүүлсэн.

Алт худалдан авах, сорьцлуулахтай холбоотой мэдээлэл

Алт олборлох зөвшөөрөл бүхий байгууллага, иргэд нь дараах материалыг бүрдүүлэн Үнэт металл сорьцын хяналын газар сорьцоо баталгаажуулан, Монголбанк, Арилжааны банкинд худалдана.

1. Үнэт металлын сорьцын хяналтын газарт үнэт металлын сорьц тогтоолгоход бүрдүүлэх материалын жагсаалт

Байгууллага:

ААНБ-ын гэрчилгээний хуулбар

Лицензийн хуулбар

Иргэн: Иргэний үнэмлэх

Алтан гулдмай сорьцлуулах төлбөрийн мэдээлэл:

0-100 грамм алтан гулдмай 10,000

101-500 грамм алтан гулдмай 20,000

501-1000 грамм алтан гулдмай 30,000

1,001-3,000 грамм алтан гулдмай 40,000

3,001-6,000 грамм алтан гулдмай 50,000

6,001-12,500 грамм алтан гулдмай 80,000

12,501-25,000 грамм алтан гулдмай 100,000

2. Монголбанкинд алт худалдахад бүрдүүлэх материалын жагсаалт

Байгууллага:

1. Лицензийн хуулбар (нэг удаа)
2. ААНБ-ын гэрчилгээний хуулбар (нэг удаа)
3. ААНБ-ын танилцуулга (нэг удаа)
4. Үнэт металлын сорьц тогтоох итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн
5. Нэхэмжлэх

Иргэн:

1. Иргэний үнэмлэх
2. Үнэт металлын сорьц тогтоох итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн
3. Банкин дахь дансны мэдээлэл

Монголбанк нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болох 5 хувийг суутган, алтны үнийг тухай бүр таны дансанд шилжүүлдэг.

Монголбанкны алт худалдан авч байгаа зорилго

1. Гадаад валютын улсын нөөцийг бүрдүүлэх голлох эх үүсвэрийн нэг нь Монгол Улсын алтны олборлолт буюу олборлосон алтаа Монголбанкинд худалдах байдал юм.
2. Гадаад валютын улсын нөөцийн удирдлагыг хууль, эрх зүйн хүрээнд Монголбанк хэрэгжүүлдэг.
3. Хариуцлагатай уул уурхайг дэмжих.

Гадаад валютын улсын нөөцийн бүтэц

1. Гадаад орны банк, санхүүгийн байгууллагад хадгалж байгаа мөнгөжсөн алт;
2. Бэлэн ба бэлэн бус хэлбэрээр байгаа чөлөөтэй хөрвөдөг гадаад валют;
3. Чөлөөтэй хөрвөдөг гадаад валютаар чөлөөтэй төлөгдөх вексель;
4. Гадаад орны Засгийн газар, төв банк, олон улсын санхүүгийн байгууллагаас гаргасан буюу баталгаажуулсан чөлөөтэй хөрвөдөг гадаад валютаар нэрлэсэн, түүгээр төлөгдөх бүх төрлийн үнэт цаас;
5. Олон улсын хэмжээнд гадаад валютын нөөцөд тооцогдох бусад актив.

Гадаад валютын нөөцийн зорилго

1. Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
2. Улс орны богино хугацаат гадаад зээлийн төлбөрийг төлөх чадварыг хангах;
3. Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн гадаад валютын баталгааг хангах, төгрөгийн ханшийг тогтвортой байлгах;
4. Улс орныг бүхэлд нь хамарсан дотоод болон гадаад хүчин зүйлийн улмаас үүссэн эдийн засгийн хямралт байдлаас түргэн хугацаанд зардал багатай гарах зэрэгт чиглэгддэг.

Төрц алт:

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3 дугаар бүлэг, 8 дугаар зүйлд заасны дагуу Монголбанк нь Монголбанкнаас зарласан алт худалдан авах үнээс 10 хувиар өндөр үнээр төрц алтыг худалдан авч Эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг баяжуулдаг.

Төрц алт худалдах харилцагчдын бүрдүүлэх материал:

1. Төрц алтыг худалдах тухай харилцагчийн гаргасан өргөдөл,
2. Геологийн төв лабораторийн шинжилгээний дүн,
3. Байгалийн тогтоц буюу төрц хэлбэрээр олдсон алт 400 граммаас дээш жинтэй байх, эсвэл жин харгалзахгүй онцгой сонин хэлбэр дүрстэй байх,
4. Уг төрц алтны гарал үүслийн мэдээллийг тодорхойлох нотлох баримт, материалтай байх.

Монголбанкинд худалдах алтанд тавигдах шаардлага

1. Үнэт металлаа анхан шатны боловсруулалт хийн хайлуулж, гулдмай болгосон байх,
2. Үнэт металлын сорьцын хяналтын газраар алтны сорьцын шинжилгээ хийлгэн агуулгыг тодорхойлуулсан дүгнэлт (сорьцын бичиг) хийлгэсэн байх.

Монголбанкинд алтаа худалдсанаар үүсэх давуу тал

1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ) 5% төлнө. (Олборлогч өөрөө экспортлоход АМНАТ 10%, экспортын зардал нэмэгдэнэ),
2. Монгол Улсын олборлон баяжуулж байгаа алтны дундаж агуулга 85.0 хувь байдаг тул алтыг олон улсын зах зээлд борлуулахад 99.99 хувийн цэвэр алт болгох шаардлагатай. Гадаадад алтыг цэвэршүүлэхэд алтны экспортын татвар, тээвэр, даатгал, хамгаалалтын зардал гардаг. Харин та Монголбанкинд алтаа худалдсанаар **Лондонгийн үнэт металлын захын үнээс 2 ам.долларыг хасаж** эрсдэлгүй, бусад нэмэлт зардалгүйгээр алтаа худалдах боломжтой.
3. Та Монголбанкинд алтаа худалдсанаар Монгол Улсын **гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх**, төгрөгийн тогтвортой байдлыг хангахад өөрийн хувь нэмрээ оруулна.
4. Таны алтанд агуулагдах цагаан мөнгөний үнийг Монголбанк тооцож төлнө.

Жингийн тайлбар

Монголд алтны худалдаачид алтыг худалдан авахдаа гол төлөв цэн-гээр үнийг нь тогтоодог бол Монголбанк граммаар тогтоож авдаг. 1 трой унци = 31.10347668 гр

Цэн, лан гэсэн хэмжигдэхүүн нь олон улс болон Монгол улсын стандартад хэрэглэгддэггүй. Грамм, килограмм нь олон улс болон Монгол улсын жингийн стандарт юм.

1 цэн = 3,7301 гр

1 лан = 37,301 гр

Монголбанкны веб: www.mongolbank.mn

Монголбанк, Эрдэнэсийн сан утас: 329677, 318624

Үнэт металлын сорьцын хяналтын газар утас: 75778430

АЛТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ТОГТООЛ, ЖУРАМ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 9 дүгээр

сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ

5 дугаар зүйл. Монголбанкны үйл ажиллагааны чиглэл

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн
найруулсан./

1.Монголбанк энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан зорилтыг хэрэгжүүлэхдээ дараахь чиглэлийн үйл ажиллагааг эрхэлнэ:

1/мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах;

2/мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;

3/Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх;

4/банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих;

5/үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих;

6/гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах;

7/банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

8/макро зохистой бодлого хэрэгжүүлэх.

21 дүгээр зүйл. Гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж, удирдах

/Энэ зүйлийн гарчигт 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

1. Монголбанк эзэмшин, удирдаж байгаа гадаад валютын улсын нөөцийн гадаад төлбөрийг түргэн гүйцэтгэх чадвар, найдвартай байдлыг хангах үүрэгтэй. Зөвхөн эдгээр үүрэг бүрэн биелсэн нөхцөлд гадаад валютын улсын нөөцийг ашиглан санхүүгийн зах зээл дээр арилжаалагдах хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх замаар орлогыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж болно.

/Энэ хэсэгт 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2. Монголбанкин дахь гадаад валютын улсын нөөц дараахь төрлийн активаас бүрдэнэ:

1/ гадаад орны банк, санхүүгийн байгууллагад хадгалж байгаа мөнгөжсөн алт;

2/ бэлэн ба бэлэн бус хэлбэрээр байгаа чөлөөтэй хөрвөдөг гадаад валют;

3/ чөлөөтэй хөрвөдөг гадаад валютаар чөлөөтэй төлөгдөх вексель;

4/ гадаад орны Засгийн газар, төв банк, олон улсын санхүүгийн байгууллагаас гаргасан буюу баталгаажуулсан чөлөөтэй хөрвөдөг гадаад валютаар нэрлэсэн, түүгээр төлөгдөх бүх төрлийн үнэт цаас;

/Энэ заалтад 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

5/ олон улсын хэмжээнд гадаад валютын нөөцөд тооцогдох бусад актив.

3. Монголбанк гадаад валютын улсын нөөцийг удирдахдаа энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гадаад валютын нөөцийн бүрэлдэхүүн хэсгийг харилцан чөлөөтэй хөрвүүлэх, худалдах, худалдан авах үйл ажиллагаа явуулж болно.

/Энэ хэсэгт 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

4. Монголбанк чөлөөтэй хөрвөдөг гадаад валют, түүнтэй адилтгах хэрэгслийг төгрөгөөр худалдах, худалдаж авахдаа төгрөгийн тогтвортой байдлыг хангана.

5. Гадаад валютын улсын нөөц нь Улсын Их Хурлаас тогтоосон доод хэмжээнээс багассан эсхүл гадаад валютын бодлогыг хэрэгжүүлэх болон улсын гадаад төлбөр тооцоог шуурхай явуулах боломж алдагдсаныг Монголбанк тодорхойлсон нөхцөлд Монголбанк Засгийн газартай хамтран холбогдох арга хэмжээ авна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 11 дүгээр сарын
17-ны өдөр

Улаанбаатар хот

ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТУХАЙ

7 дугаар зүйл. Монголбанкны бүрэн эрх

Монголбанк эрдэнэсийн сангийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/эрдэнэсийн сангийн хөдөлгөөний бүртгэл, тооцоог эрхлэх;

2/хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу үндсэн болон гүйлгээний сангийн орлогыг нэмэгдүүлж зарлагын гүйцэтгэлийг хангах;

3/эрдэнэсийн гүйлгээний санд байгаа үнэт металлаас олон улсын жишигт хүргэн дотоод, гадаадад цэвэршүүлж, гадаадын банк, санхүүгийн байгууллагад оновчтой байршуулах;

/Энэ заалтад 2002 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

4/эрдэнэсийн үндсэн сангаас үнэт металл, үнэт чулуу гадаадад худалдах, гадаадаас худалдан авч нөөц нэмэгдүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж гаргасан шийдвэрийг нь хэрэгжүүлэх;

/Энэ заалтад 2002 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

5/эрдэнэсийн сангийн эрдэнэсийн үнэ тогтоох журам баталж мөрдүүлэх;

6/хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

15 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт эрдэнэс эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

1//Энэ заалтыг 1997 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

2/эрдэнэсийн санд худалдах үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийг сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар сорьц тогтоолгон баталгаажуулсан байх;

/Энэ заалтад 2002 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хууль, 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/

3/үнэт металл, эрдэнийн чулуугаар хийсэн түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг эзэмшиж байгаа бол түүний жинхэнэ эхийг эрдэнэсийн санд хадгалуулах. Ийнхүү хадгалуулбал зохих зүйлийн жагсаалтыг Монголбанкны Ерөнхийлөгч, Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

/Энэ заалтад 2002 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

2. Аж ахуйн нэгж, иргэн нь эрдэнэсийн санд худалдах болон хадгалуулах эрдэнэсийн үнийг хэлэлцэн тохирох, нэхэмжлэн авах эрхтэй.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 7 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ

(Шинэчилсэн найруулга)

46 дугаар зүйл. Үнэт металл, эрдэнийн чулууг бүртгэх, худалдах

46.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон бүх төрлийн үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар тогтоолгож, тоо хэмжээг бүртгүүлнэ.

/Энэхэсэгт 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

46.2. Энэ хуулийн 46.1-д заасны дагуу бүртгүүлбэл зохих үнэт металл, эрдэнийн чулууны жагсаалт, тэдгээрийн сорьц, чанарыг тогтоох, бүртгэх журмыг Засгийн газар батална.

46.3. Үнэт металл, эрдэнийн чулууг Монголбанк худалдан авч төлбөр хийхдээ олон улсын зах зээлийн үнийг баримтална.

46.4. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон үнэт металл, эрдэнийн чулууг Монголбанкаар дамжуулан экспортод гаргаж болно.

46.5. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 400 граммаас дээш жинтэй, эсхүл түүнээс хөнгөн боловч онцгой чамин дүрс хэлбэртэй байгалийн төрц алт, түүнчлэн ховор өнгө, дүрстэй эрдэнийн чулуу олборлосон бол тэдгээрийг Монголбанкны төрийн эрдэнэсийн санд урамшуулалтай үнээр худалдах үүрэгтэй.

47 дугаар зүйл. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

47.1. Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банкинд алт тушаасан этгээд нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг

худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.

/Энэ хэсэгт 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

47.2.Энэ хуулийн 47.1-д заасан борлуулалтын үнэлгээг дараахь журмаар тооцно:

47.2.1.экспортод бүтээгдэхүүн гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан;

47.2.2.дотоодод борлуулсан буюу ашигласан бол тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнийг үндэслэн;

47.2.3.дотоод, гадаадын зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний зах зээлийн жишиг үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдүүлсэн борлуулалтын орлогыг үндэслэн.

47.3.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр дараахь хэмжээтэй байна:

47.3.1.дотоодод борлуулж байгаа нүүрсний нөөц ашигласны төлбөр тухайн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү;

/Энэ заалтад 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

47.3.2.Энэ хуулийн 47.3.1-т зааснаас бусад төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн доод хэмжээ нь тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5,0 хувь, Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банкинд тушаасан алтанд ногдох энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү.

/Энэ заалтад 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтад 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/
/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн
найруулсан/

47.3.3.Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд энэ хуулийн 47.3.2-т заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 2,5 хувь, энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү.

/Энэ заалтыг 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн бөгөөд
энэ заалтыг 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн 2019 оны 01 дүгээр
сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө/

47.4.Тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч энэ хуулийн 47.3.2-т заасан хувь дээр мөн хуулийн 47.5-д заасан хувийг нэмсэн дүнгээр тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулна.

47.5.Энэ хуулийн 47.4-т заасан нэмэлт төлбөрийн хувийг дараахь байдлаар тодорхойлно:

47.6.Энэ хуулийн 47.3.1, 47.3.2, 47.4, 47.5-д заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журмыг Засгийн газар батална.

/Энэ хэсгийг 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

47.7.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хүдэр, баяжмал, бүтээгдэхүүнд давхардуулахгүйгээр ногдуулна.

/Энэ хэсгийг 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн
найруулсан/

47.8.Энэ хуулийн 47.5-д заасан хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлалыг геологи, уул уурхайн болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

/Энэ хэсгийг 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/

47.9.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын ажлын явцад туршилтын журмаар олборлосон ашигт малтмалын төрөл,

тоо, хэмжээг мэргэжлийн хяналтын албанд бүртгүүлж зөвшөөрөл авсны үндсэн дээр худалдан борлуулж болох бөгөөд энэ тохиолдолд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нэгэн адил төлнө.

/Энэ хэсгийн дугаарыг 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчилсөн/

47.10.Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банкинд алт тушаасан этгээдээс бусад энэ хуулийн 47.1-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн ашигт малтмалд ногдох тухайн сарын төлбөрийг дараагийн сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайлангаар хийсэн эцсийн тооцоогоо дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор төсөвт төлнө.

/Энэ хэсгийн дугаарыг 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчилсөн/

/Энэ хэсгийг 2015 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

47.11.Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банкинд алт тушаасан этгээдээс бусад энэ хуулийн 47.1-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь тухайн улиралд олборлож худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан ашигт малтмалын тоо хэмжээ, борлуулалтын үнэлгээ, төлбөрийн нийт хэмжээг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу улирал тутам өссөн дүнгээр гаргаж, улирлын тайланг дараагийн улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ.

/Энэ хэсгийн дугаарыг 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчилсөн/

/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

47.12.Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банк нь энэ хуулийн 47.3.2-т заасан хувь хэмжээгээр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тушаасан алтны борлуулалтын үнэлгээнээс суутган авч, улсын төсөвт шилжүүлнэ.

/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн/

47.13.Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банк нь энэ хуулийн 47.12-д заасны дагуу төсөвт шилжүүлсэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан, мэдээг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу дараа сарын 20-ны өдрийн дотор тус байгууллагад хүргүүлнэ.

/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн/

47.14.Экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох олон улсын жишиг үнэ тогтоодог биржийн нэрийг тухайн бүтээгдэхүүний нэр төрлийг харгалзан Засгийн газар нийтэд зарлана.

/Энэ хэсгийн дугаарыг 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчилсөн/

/Энэ хэсгийн дугаарыг 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчилсөн/

47.15.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу тогтворжуулах гэрчилгээ бүхий татвар төлөгчийн тухайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр ногдуулна.

/Энэ хэсгийг 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ хэсгийн дугаарыг 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчилсөн/

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 7 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

ВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ

8 дугаар зүйл. Монголбанкны бүрэн эрх

Монголбанк нь валютын зохицуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 1/ улсын хэмжээнд валютын гүйлгээг зохицуулж, хэрэгжүүлэх;
- 2/ улсын валютын гадаад нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
- 3/ Монгол Улсын болон гадаадын валютын зах дээр эрх хэмжээнийхээ дотор валютын гүйлгээ, гадаад төлбөр, тооцоо эрхлэх;
- 4/ төрийн өмчид байвал зохих валютын гадаад цэвэр нөөцийн доод хэмжээ тогтоох тухай санал боловсруулж шийдвэрлүүлэх, түүнийг хадгалах, оновчтой, үр ашигтай байршуулах;
- 5/ Засгийн газрын валютын гүйлгээ, гадаад төлбөр, тооцоог гүйцэтгэх;
- 6/ байнга оршин суугчид гадаад төлбөр, тооцоо хийх болон гадаад бэлэн валютаар гүйлгээ эрхлэхэд хяналт тавих;

/Энэ заалтыг 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

- 7/ валютын гүйлгээний тайлан, мэдээ гаргах журмыг тогтоох;
- 8/ валютын гүйлгээний нэгдсэн тайлан, мэдээг Улсын Их Хуралд улирал бүр оруулж байх;
- 9/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

10 дугаар зүйл. Монголбанкны эрхлэх валютын гүйлгээ

1. Монголбанк нь Монгол Улсын валютын гадаад нөөцийг

нэмэгдүүлэх, зохицуулах зорилгоор тус улсын болон гадаад орны банк, бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс валют, цэвэршүүлсэн алт худалдан авч болно.

2. Монголбанк нь төгрөгийн ханшийг тогтвортой байлгах зорилгоор өөрийн эзэмшилд байгаа валютын гадаад нөөцөөс гадаад валютыг худалдана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 7 дугаар сарын
4-ний өдөр

Дугаар 220

Улаанбаатар хот

ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.3, 47.6, 47.12-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах аргачлал”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Гадаадын зах зээлд борлуулсан нүүрсэнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох аргачлал”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай. /Энэ тогтоолын 1-р хавсралтад ЗГ-ын 2015 оны 103-р тогтоолоор нэмэлт орсон бөгөөд үүнийг 2015-4-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Мөн тогтоолын 2-р хавсралтад ЗГ-ын 2016 оны 81-р тогтоолоор өөрчлөлт орсон/

2. ~~“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2014 оны 89 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай. /Энэ заалтыг ЗГ-ын 2016-2-1-ний өдрийн 81-р тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/~~

~~—“4. Энэ тогтоолын 2 дугаар зүйлийн 6-д заасан гэрээний үнийг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл, 61 дэх хэсэгт заасан эх сурвалжийг 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн дагаж мөрдсүгэй.”~~

3. Энэ тогтоол батлагдан гарсантай холбогдуулан “Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2014 оны 88 дугаар тогтоол, “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2014 оны 89 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Улаан, Уул уурхайн сайд Д.Ганхуяг нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.АЛТАНХУЯГ

Сангийн сайд Ч.УЛААН

Засгийн газрын 2014 оны 220 дугаар
тогтоолын 1 дугаар хавсралт

АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВИЙГ ТООЦОХ, ТӨЛБӨР НОГДУУЛАХ АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн эдэлбэр газраас олборлож худалдсан эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн бүтээгдэхүүнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулахад энэ аргачлалыг мөрдөнө.

Хоёр. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, ногдуулах

2.1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдох борлуулалтын үнэлгээг дараах байдлаар тооцно:

2.1.1. төмрийн хүдэр, нүүрснээс бусад ашигт малтмалыг өөрөө эсхүл бусдаар дамжуулж экспортолсон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн сард гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд мэдээлсэн тухайн сард баримтлах зах зээлийн үнийг үндэслэн; /Энэ заалтад ЗГ-ын 2015-3-16-ны өдрийн 103-р тогтоолоор нэмэлт орсон бөгөөд үүнийг 2015-4-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

2.1.2. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өөрөө эсхүл бусдаар дамжуулж тухайн сард экспортолсон нүүрсний борлуулалтын үнэлгээг Засгийн газраас баталсан “Тадаадын зах зээлд борлуулсан нүүрсэнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох аргачлал”-ын дагуу;

2.1.3. Монголбанк болон түүний эрх олгосон банкинд худалдсан мөнгө болон Ашигт малтмалын тухай хуулийн 47.3.3-т

заасан алтны борлуулалтын үнэлгээг Монголбанкнаас тухайн өдөр зарласан үнийг баримтлан;

2.1.4. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн сард олборлож дотоодын зах зээлд худалдсан, ашигласан ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг тухайн бүтээгдэхүүний эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнийг үндэслэн.

2.2. Засгийн газрын тогтоосон үнийн эх сурвалжид үндэслэн өмнөх сарын үнийн дунжийг тооцох зарчмаар мэдээлсэн үнийг үнэ зарласан тухайн сард төлөх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг тооцоход ашиглана.

Гурав. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төсөвт төлөх, тайлагнах

3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн сард худалдсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг дараа сарын 10-ны дотор улсын төсөвт төлнө.

3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монголбанк болон түүний эрх олгосон банкинд алт, мөнгө худалдсан, тушаасан тухай бүр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн банкинд төлнө.

3.3. Монголбанк болон арилжааны банк иргэд, хуулийн этгээдийн тушаасан алт, мөнгөний борлуулалтын үнэлгээнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тушаасан тухай бүр суутгаж, ажлын 10 хоногийн дотор улсын төсвийн дансанд шилжүүлнэ.

3.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эдэлбэр талбайд орших ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдоогүй ашигт малтмалыг өөр бусад этгээдэд худалдах, ашиглуулах замаар боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, гадаад, дотоодын зах зээл дээр борлуулсан нь түүнийг тухайн ашигт малтмалын нөөцөд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх үүргээс чөлөөлөхгүй.

3.5. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн улирал, жилийн эцсийн тайлангаар энэ аргачлалын 2.2-т заасны дагуу тооцсон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдлыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд мэдээлсэн тухайн сар бүрийн үнийн дагуу залруулж эцсийн тооцоог хийнэ.

Дөрөв. Хяналт тавих

4.1. Энэ аргачлалын хэрэгжилтэд Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Ашигт малтмалын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар байнгын хяналт тавьж ажиллана.

4.2. Тухайн сард экспортоор гарсан ашигт малтмалын бүтээгдэхүүний мэдээг Гаалийн ерөнхий газраас дараа сарын 5-ны өдрийн дотор Сангийн яам, Уул уурхайн яам, Татварын ерөнхий газарт албан бичгээр болон цахим сүлжээгээр хүргүүлж байна.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2017 оны 12 дугаар сарын
27-ны өдөр

Дугаар А-332

Улаанбаатар хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 7, 9, 12, 13, 14 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (Ж.Ганбаатар), Тайлан бүртгэлийн газар (Т.Амарсайхан)-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн А-19 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Ж.Батхуяг)-т даалгасугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАЯРТСАЙХАН

ГУРАВ. (ҮНЭТ МЕТАЛЛ) АЛТАН ГУЛДМАЙ ХУДАЛДАН АВАХ, ХУДАЛДАХ, ТҮР ХУГАЦААГААР ХАДГАЛАХ

3.1. Эрдэнэсийн санд үнэт металл худалдан авах, худалдах, түр хугацаагаар хадгалах, хүлээн авах цагийн хуваарийг Эрдэнэсийн сангийн захирал батална.

3.2. Харилцагч нь дараах шаардлагыг хангасан үнэт металлыг Эрдэнэсийн санд худалдана. Үүнд:

3.2.1. нунтаг шороон хэлбэрээр олборлосон үнэт металлаа анхан шатны боловсруулалт хийн хайлуулж, гулдмай болгосон (цаашид алтан гулдмай гэх) байх,

3.2.2. алтан гулдмайд сорьц тогтоох эрх бүхий байгууллага (цаашид сорьцын байгууллага гэх)-аар сорьцын шинжилгээ хийлгэн агуулгыг тодорхойлуулсан дүгнэлт (сорьцын дүгнэлт) хийлгэсэн баталгаажсан баримттай байх,

3.2.3. сорьцын байгууллага дээр алтан гулдмай тус бүрийг тусгай уут, саванд хийн, битүүмжилж, лацадсан байх,

3.2.4. алтан гулдмайн чанар нь Сорьцын хяналтын хэлтсийн лабораториос олгосон сорьц тодорхойлсон шинжилгээний дүнгээр баталгаажна. Жингийн зөрүү гарсан тохиолдолд Монголбанкны хүлээн авсан жингээр тооцно.

3.3. Энэхүү журмын 3.2.3-д заасан шаардлага нь банкнаас худалдаж буй алтан гулдмай болон хил, гааль, хууль, хяналтын байгууллагад хураагдсан алтан гулдмайд үл хамаарна.

3.4. Харилцагч нь дараах тохиолдолд алтан гулдмайг Эрдэнэсийн санд ажлын 3 (гурав) хоног хүртэл түр хугацаагаар хадгалуулж болно. (Хавсралт 1) Үүнд:

3.4.1. Алтан гулдмайн сорьцын дүгнэлт нь тухайн өдрийн гүйлгээний цагт амжиж гараагүй,

3.4.2. Давагдашгүй хүчин зүйлс болон техникийн саатал (цахилгаан тасрах, сүлжээ доголдох гэх мэт) тохиолдсон,

3.4.3. Гүйлгээ хийх хуваарьт цагт багтаж төлбөр тооцоог хийж амжаагүй.

3.5. Харилцагч нь түр хадгалуулсан албан гулдмайг журмын 3.4-т заасан хугацаанд багтаж Эрдэнэсийн санд худалдаагүй бөгөөд хадгалалтын хугацаа дуусах өдөр эсхүл дууссаны дараа алтан гулдмайг хадгалуулснаас хойш ажлын 3 (гурав) дах өдрийн Монголбанкнаас зарласан, дотоодын зах зээлээс алтан гулдмай худалдан авах үнээр холбогдох төлбөр тооцоог хийнэ. (Хавсралт 2)

3.6. Харилцагч түр хадгалуулж буй албан гулдмайг буцаан авах тохиолдолд акт үйлдэж, буцаан олгоно. (Хавсралт 3)

3.7. Энэхүү журмын 3.2, 3.4-т заасан шаардлага нь хил, гааль, хууль хяналтын байгууллагаас хадгалуулсан алтан гулдмайд үл хамаарна. Хил, гааль, хууль хяналтын байгууллага алт, үнэт зүйлийг Монголбанкинд хадгалуулахад дараах баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

3.7.1. Тухайн алт, үнэт зүйлийг хадгалуулах албан бичиг,

3.7.2. Эд мөрийн баримт хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл.

3.8. Эрдэнэсийн сан нь алтыг миллиграмм (мгр)-ын, цагаан мөнгийг грамм (гр)-ын нарийвчлалтайгаар жинлэн хүлээн авч, төлбөр тооцоог хийнэ.

3.9. Эрдэнэсийн сангийн Улсын нярав, нярав Эрдэнэсийн санд алтан гулдмай худалдах, эсвэл түр хугацаагаар хадгалуулахаар ирсэн харилцагчийн биеийн байцаалт, үнэмлэх, итгэмжлэл болон холбогдох баримт бичгийн бүрдэлд хяналт тавина.

3.10. Эрдэнэсийн сангийн улсын нярав, нярав худалдах, эсвэл хадгалуулах алтан гулдмайг харилцагчийг байлцуулан уут, савны битүүмжлэлийг сайтар шалган, лацны дугаарыг тулган үзсэний дараагаар алтан гулдмай тус бүрийг жинлэн, алтан гулдмай хүлээн авсан актыг үйлдэнэ. (Хавсралт 2)

3.11. Алтан гулдмайн уут, савны битүүмжлэл алдагдсан, лац хөдөлсөн, лацны дугаар зөрсөн тохиолдолд алтан гулдмайг хүлээн авахгүй.

3.12. Эрдэнэсийн сангийн захирал Эрдэнэсийн санд худалдаж буй алтан гулдмайг хүлээн авсан акт, худалдаж авах мэдээллийн бүрдэлд хяналт тавьж, гарын үсэг зурж, алтан гулдмай худалдан авах зөвшөөрөл олгоно.

3.13. Алтан гулдмай хүлээн авсан акт, худалдаж авах зөвшөөрлийг ахлах нягтлан бодогч болон нягтлан бодогчид хүлээлгэн өгнө.

3.14. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс худалдан авч байгаа алтан гулдмай дахь алт, мөнгөний цэвэр жинг дараах томъёог ашиглан тооцно.

- Алтан гулдмай худалдах, худалдан авах алтан гулдмай дахь алтны цэвэр жинг тооцох.

$$\text{Цэвэр жин} = \text{Бохир жин} * \frac{\text{Сорьц}}{1000} * \frac{999.9^{\circ}}{1000}$$

- Алтан гулдмай худалдах, худалдан авах алтан гулдмай дахь мөнгөний цэвэр жинг тооцох.

$$\text{Цэвэр жин} = \text{Бохир жин} * \frac{\text{Сорьц}}{1000} * \frac{999^{\circ}}{1000}$$

(Алтан гулдмай дахь алт, мөнгөний цэвэр жинг тооцохдоо дээрхи томъёог ашиглах бөгөөд сорьцын байгууллагын сорьцын дүгнэлт дэх сорьцын үзүүлэлтийг орон дэвшүүлэхгүйгээр шууд тооцоонд хэрэглэнэ).

3.15. Нягтлан бодогчийн үүсгэсэн гүйлгээний баримтын бүрдэлд дараалсан хяналтыг ахлах нягтлан бодогч хийж тухайн гүйлгээг батална.

3.16. Харилцагчаас түр хадгалуулсан алтан гулдмайг харилцагчийн хүсэлт болон шийдвэрийг үндэслэн буцаан олгох эсвэл улсын орлого болгох хүртэл түр хугацаагаар тэнцлийн гадуурхи дансанд бүртгэнэ.Үүнд:

3.16.1 Энэхүү журмын 3.4-т заасны дагуу алтан гулдмайг түр хадгалуулсан,

3.16.2 Хил гааль болон хууль хяналтын байгууллагад хураагдсан эд мөрийн баримт болох алтан гулдмай болон бусад эд зүйлс.

3.17. Энэхүү журмын 3.16.2-т заасан алтан гулдмайг улсын орлого болгохдоошүүхийн шийдвэрт алтан гулдмайн үнийн дүнг тусгасан тохиолдолд тус үнийн дүнгээр холбогдох төлбөр тооцоог хийнэ.

3.18. Энэхүү журмын 3.16.2-т заасан алтан гулдмайг улсын орлого болгохдоо шүүхийн шийдвэрт алтан гулдмайн үнийн дүнг тусгаагүй тохиолдолдалтан гулдмайг улсын орлого болгох тухай шүүхийн шийдвэр гарсан өдрийн, Монголбанкнаас зарласан, дотоодын зах зээлээс алтан гулдмай худалдан авах үнээр холбогдох төлбөр тооцоог хийнэ.

3.19. Харилцагчаас худалдсан, эсвэл түр хугацаагаар хадгалуулсан алтан гулдмайн жагсаалт үйлдэнэ.

3.20. Алтан гулдмайг хүлээн авсан огноо, харилцагчийн нэр, нийт жин, дугаар, тоо ширхэгийг алтан гулдмай дээр наах шошго буюу хаягт бичнэ.

3.21. Жинлэн хүлээн авсан алтан гулдмайг тусгай зориулалтын хүндрүүлэгчтэй сейфэнд тухайн ажлын өдрийн туршид Эрдэнэсийн сангийн улсын нярав, няравын хариуцлагад түр хадгалах бөгөөд уг алтан гулдмайн үзүүлэлтүүдийг агуулахын дэвтэрт бүртгэнэ.

3.22. Эрдэнэсийн сангийн захирал, ахлах нягтлан бодогч нарын дараалсан хяналт дор алтан гулдмай бүрийг дахин жинлэн, алтан гулдмай дээр наасан шошгоны үзүүлэлттэй тулган шалгасны эцэст Эрдэнэсийн сангийн агуулахад оруулна.

3.23. Алтан гулдмайг энэхүү журмын 3.19-д заасан агуулахын жагсаалтад бичигдсэн үзүүлэлттэй тохирч байгаа эсэхийг Эрдэнэсийн сангийн захирал, Улсын нярав, ахлах нягтлан бодогч нар давхар тулган шалгаж, гарын үсэг зурж баталгаажуулна.

3.24. Эрдэнэсийн сангийн улсын нярав, нярав нь агуулахын дэвтэр дэх бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн холбогдох дансдын хуулга, тэнцлийн гадуурх дансдын хуулганы үлдэгдэл дүнтэй тохирч байгаа эсэхийг гүйлгээ хийгдсэн өдөр бүр тулган шалгана.

3.25. Гүйлгээ сан дахь худалдан авсан алтан гулдмайг сар, улирал, жилийн эцсээр тогтмол тоолж, холбогдох данс, агуулахын бүртгэлтэй тулган шалгаж, тооллого хийсэн тухай акт үйлдэн, ахлах нягтлан бодогч, Эрдэнэсийн сангийн захирал, улсын нярав нар нарын үсэг зурж баталгаажуулна.

3.26. Үндсэн болон гүйлгээ сан дахь алтан гулдмай, үнэт металаар цутгасан зоос, үнэт, болон хагас үнэт чулуугаар хийсэн эдлэл, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлсийн орлого, зарлагадбүртгэлийн картыг хөтөлнө.

3.27. Харилцагч нь “Эрдэнэсийн санд үнэт металл худалдан авах цагийн хуваарь”-т багтаж алтан гулдмайгаа Монголбанкинд тушааж амжаагүй тохиолдолд 3.28 дахь заалтын дагуу шийдвэрлэж болно.

3.28. Тайлан бүртгэлийн газар дараах баримтыг үндэслэн, харилцагчийн төлбөрийг алтан гулдмай хүлээн авсан өдрийн Монголбанкнаас зарласан, дотоодын зах зээлээс алт, мөнгө авах үнээр тооцон, дараагийн ажлын өдөр 9:00-11:00 цагийн хооронд харилцагчийн дансанд шилжүүлнэ. Үүнд:

3.28.1. Харилцагчийн төлбөрийн нэхэмжлэх,

3.28.2. Алтан гулдмай хүлээлгэн өгсөн өдөр үйлдсэн харилцагчийн гаргасан хүсэлт, төлбөр шилжүүлэх зөвшөөрөл. (Хавсралт 4)

3.29. Эрдэнэсийн сангийн гүйлгээ сангаас цэвэршүүлсэн алт, мөнгийг байгууллага, иргэний хүсэлтээр худалдаж болно. Худалдан

борлуулах үнэ, тоо хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.

3.30. Эрдэнэсийн санд үнэт металл худалдсан харилцагчид Монголбанкнаас гэрчлэх бичгийг батлагдсан загвараар олгож болно. (Хавсралт 5)

3.31. Эрдэнэсийн сан гэрчлэх бичгийн дугаарыг дэс тоогоор дарааллуулан бичиж, бүртгэл хөтөлнө.

3.32. Гэрчлэх бичиг нь олгосон өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.

